



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/194

Булган сум



Насны I, II ангийн ойд арчилгааны
огтлолт хийх эрх шилжүүлэх тухай



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ойн таварлаг чанарыг нэмэгдүүлэх зорилгоор насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх” төсөл арга хэмжээний 28,000,000 (хорин найман сая) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2. Насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх ажлыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-тай гэрээ байгуулж, хавсралтад тусгагдсан арга хэмжээг хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг Булган сум дундын Ойн ангийн дарга (Б.Алтансүх), Хялганат сум дундын Ойн ангийн дарга (М.Нямжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Ойн таварлаг чанарыг нэмэгдүүлэх зорилгоор насны I, II ангийн ойд арчилгааны огтлолт хийх (70га, Бугат, Орхон, Хангал сум)” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.


4. Гэрээ байгуулах эрх олгосон арга хэмжээг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



03 дугаар сарын 28-ны/ний өдрийн 17/195 дүгээр захирамжийн хавсралт



Ойн ангийн насны I, II ангийн ойд арчилгааны
огтлолт хийх зардлын хуваарилалт

д/д	Ажлын нэр төрөл	Батлагдсан төсөвт өртөг (төг)	Эрх шилжүүлсэн Ойн ангийн даргын нэр
1	2	3	4
1	Булган сум дундын Ойн анги	18,000,000	Б.Алтансүх
2	Хялганат сум дундын Ойн анги	10,000,000	М.Нямжаргал
Нийт		28,000,000	